

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
О.НАРАНДЭЛГЭР ТАНАА:

ИЛТГЭХ ХУУДАС

“Компанийн Санхүү бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлтэд хяналт, мониторинг хийсэн тухай

2022.10.12

Дугаар.03

Улаанбаатар хот

Нэг. Хяналт, мониторингын зорилго ба цар хүрээ

1.1 Хяналт, мониторингын зорилго нь Компанийн санхүү бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлтийн хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаал “Маягт заавар батлах тухай” заалтыг мөрдлөг болгон, түүгээр батлагдсан анхан шатны бүртгэлийн маягтуудыг хөтөлж байгаа эсэхэд дүгнэлт өгөх, илэрсэн алдаа дутагдлын шалтгаан нөхцлийг тогтоож, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргаж, зөвлөмж өгч холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд чиглэгдэнэ.

НББОУСтандарт, “Компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”, “2022 оны компанийн хяналт, мониторинг хийх ажлын төлөвлөгөө” зэргийг тус тус үндэслэн, төлөвлөгөөт дотоод хяналт, мониторингын ажлыг хийж гүйцэтгэлээ.

1.2. Хяналт, мониторингын хамрах хүрээ

1. Анхан шатны баримт нь дугаар алгасгахгүй, давхардуулахгүйгээр хөрөнгийн данс бүрээр болон хөрөнгийн орлогын гүйлгээ, зарлагын гүйлгээ тус бүрээр тус тусдаа дугаарлагдсан эсэх;
2. Анхан шатны баримтанд ажил гүйлгээ хийгдсэн огноог үнэн зөв бичсэн эсэх;
3. Анхан шатны баримтанд ажил гүйлгээний нөгөө тал буюу харилцагчийн албан ёсны нэр хаяг, гүйлгээний утгыг бүрэн зөв тодорхой бичсэн эсэх;
4. . Анхан шатны баримт үйлдсэний дараа, түүнд дэмжих баримтуудыг хавсарган зохих албан тушаалтнаар хянуулж, батлуулсан эсэх;
5. Анхан шатны баримтанд түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан эсэх;
6. . Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан эсэх;

1.3. Хяналт, мониторинг хийсэн бүрэлдэхүүн:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Сайнжаргал

1.4. Хяналт, мониторингод хамрагдсан хэлтэс

Захиргаа, санхүүгийн хэлтэс

1.5. Хяналт мониторингд хамрагдсан хугацаа

2022 оны 1 дугаар сарын 01-нээс 2022 оны 10 дугаар сар хүртэл

1.6. Хяналт, мониторинг хийсэн хугацаа

2022 оны 9 дүгээр 18-нээс 2022 оны 10 дугаар сарын 12-н хүртэл

Компанийн Санхүү бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлтэд хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд Захиргаа, удирдлага санхүүгийн хэлтсээс гаргуулж авсан баримт материалын жагсаалт:

1. Компанийн бүх харилцах дансны хуулга
2. Бэлэн мөнгөний орлого зарлагын баримт /НХМаягт МХ-1,2/
3. Бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөл /НХМаягт МХ-3/
4. Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан /НХМаягт МХ-4/
5. Бэлэн мөнгөний тооллогын баталгаа /НХМаягт МХ-5/
6. Бараа материал хүлээн авалтын баримт /НХМаягт БМ-1/
7. Орлогын баримт /НХМаягт БМ-2/
8. Зарлагын баримт /НХМаягт БМ-3/
9. Шаардах хуудас /НХМаягт БМ-6/
10. Ажлын цагын тооцоо /НХМаягт ЦХ-2/
11. Цалингын тооцооны карт /НХМаягт ЦХ-4/
12. Цалин олгох хүснэгт /НХМаягт ЦХ-5а,5б/
13. Нэхэмжлэх /НХМаягт ТМ-1/
14. Мөнгөн урьдчилгааны тайлан /НХМаягт ТМ-2/
15. Төлбөрийн баримт /НХМаягт ТМ-5/

Хоёр. Хяналт, мониторингын үр дүн

Дотоод хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ 2022 оны 1 дугаар сарын 01-нээс 2022 оны 9 дугаар сарыг дуустал хугацааг хамааруулан хийж гүйцэтгэлээ.

1. Анхан шатны баримт нь дугаар алгасгахгүй, давхардуулахгүйгээр хөрөнгийн данс бүрээр болон хөрөнгийн орлогын гүйлгээ, зарлагын гүйлгээ тус бүрээр тус тусдаа дугаарлагдсан байна.
2. Анхан шатны баримтанд ажил гүйлгээ хийгдсэн огноог үнэн зөв бичсэн байна.
3. Анхан шатны баримтанд ажил гүйлгээний нөгөө тал буюу харилцагчийн албан ёсны нэр хаягыг бүрэн гүйцэд тусгасан, харин зарим гүйлгээний утгыг бүрэн, зөв тодорхой бичээгүй байна.
4. Анхан шатны баримт үйлдсэний дараа, түүнд дэмжих баримтуудыг хавсарган зохих албан тушаалтнаар хянуулж, батлуулсан, харин зарим дэмжих баримтууд нь бүрэн, зөв тодорхой биш байна.
5. Анхан шатны баримтанд түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна.
6. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаагүй байна.

Хяналт мониторингийн дүгнэлт:

1. НББОУСтандартын дагуу анхан шатны баримт бүрдүүлэлтийг хийж гүйцэтгэсэн байна.
2. "Компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-д тусгагдсан анхан шатны баримт бүрдүүлэлтэнд тавигдах шаардлагын дагуу анхан шатны баримт бүрдүүлэлтийг хийж гүйцэтгэсэн байна.
3. Анхан шатны баримтанд зарим харилцагчийн гүйлгээний утгыг бүрэн, зөв тодорхой бичээгүй дутагдал байна.
4. Анхан шатны баримтыг дэмжих зарим баримтууд нь бүрэн, зөв тодорхой биш байна.
5. Дотоод томилолтын зарлагын анхан шатны зарим баримтууд нь бүрэн, зөв тодорхой биш байна.
6. Дотоод томилолтын болон ажил үйлчилгээ гүйцэтгэсэн зарим тайланд компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үр дүнг тодорхой тусгаагүй байна.

Хяналт мониторингийн зөвлөмж:

1. Бүх анхан шатны баримтанд харилцагчийн гүйлгээний утгыг бүрэн, зөв тодорхой тусгах шаардлагатай байна.
2. Анхан шатны баримтыг дэмжих баримтууд нь бүрэн, зөв тодорхой байх хэрэгтэй байна.
3. Дотоод томилолтын зарлагын анхан шатны баримтууд нь бүрэн, зөв тодорхой байх шаардлагатай байна.
4. Дотоод томилолтын болон ажил үйлчилгээ гүйцэтгэсэн тайланд компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үр дүнг тодорхой тусгах хэрэгтэй байна.

Хяналт, мониторингын зөвлөмжийн хүрээнд хийсэн ажил, үр дүнгийн тайланг 2022 оны 12 дүгээр сарын 01-нээс өмнө Захиргаа,санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Сайнжаргал-д илгээнэ үү.

Хяналт мониторинг хийж, дүгнэлт,зөвлөмж боловсруулсан:
Захиргаа,санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

О.Сайнжаргал